



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 522

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааг
дахин зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22,435,636.30 (хорин хоёр сая дөрвөн зуун гучин таван мянга зургаан зуун гучин зургаан төгрөг гучин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашины 3 дахь дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2. Автомашины худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

3. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаранд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

3.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу дуудлага худалдааг зохион байгуулах зардлыг хассан дүнгээр байгууллагын дансанд төвлөрүүлэх;

3.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


3.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Б. ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 32-ны өдрийн
302 дугаар тогтоолын хавсралт

**"Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, дахин
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2018 оны 349 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ шинэчлэн тогтоосон
1	УАЗ-22069 марк, 61-56 УБӨ улсын дугаартай, Арлын дугаар -704727758	2004/2004	107002	16,935,636.30	7,500,000.00	1,500,000.00
2	Ниссан Санни марк, 52-00 ӨВА улсын дугаартай, Арлын дугаар -ЕВ15020791	1999/2008	212200	5,500,000.00	2,500,000.00	1,500,000.00
				22,435,636.30	10,000,000.00	3,000,000.00
	Нийт дүн			22,435,636.30 (хорин хоёр сая дөрвөн зуун гучин таван мянга зургаан зуун гучин зургаан төгрөг гучин мөнгө)	10,000,000 (арван сая)	3,000,000.00 (гурван сая)